

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Нийтийн номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/31/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор Э.Сүнжидмаа Утас: 99029885 Цахим хаяг: Sunjidmaae@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	Error! Bookmark not defined.
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	Error! Bookmark not defined.
3.8 Аудитын гол асуудал.....	Error! Bookmark not defined.
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
БСУГ	Боловсрол соёл урлагийн газар



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.24 № 40
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Нийтийн номын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Нийтийн номын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Түрээсийн орлого 0.3 сая төгрөгийг төвлөрүүлээгүй, ур чадварын нэмэгдэл 0.4 сая төгрөгийг илүү тооцож олгосон, хөрөнгийн тооллогоор 3.5 сая төгрөгийн хөрөнгийг шийдвэргүйгээр шилжүүлсэн, 2.7 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй, татварын тодорхойлолт, санхүүгийн тайлан 2.7 сая төгрөгөөр зөрүүтэй, хэмнэлтийн гормыг зөрчиж 9.1 сая төгрөгийн цалин олгосон, түрээсийн орлогыг тооцож үзэхэд 4.7 сая төгрөгийн орлого олох боломжийг алдсан зэрэг нь АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

07020116

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	20,579,819.40	24,845,693.40
33	АВЛАГА	1,560,069.40	2,787,793.40
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	560,069.40	560,069.40
33500	Бусад авлага	1,000,000.00	2,227,724.00
33510	Байгууллагаас авах авлага	0.00	0.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	1,000,000.00	2,227,724.00
35	БАРАА МАТЕРИАЛ	19,019,750.00	22,057,900.00
35100	Түүхий эд материал	1,639,500.00	2,121,500.00
35110	Тусгай зориулалттай материал	1,639,500.00	2,121,500.00
35400	Хангамжийн материал	17,380,250.00	19,936,400.00
35410	Бичиг хэргийн материал	780,700.00	629,900.00
35420	Аж ахуйн материал	10,736,300.00	13,574,500.00
35430	Сэлбэг хэрэгсэл	0.00	0.00
35440	Түлш, шатах тослох материал	131,250.00	0.00
35450	Барилгын засварын материал	129,500.00	129,500.00
35460	Хүнсний материал	0.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	5,602,500.00	5,602,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,520,867,460.64	1,504,182,650.66
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,520,867,460.64	1,504,182,650.66
39100	Газар	0.00	0.00
39200	Биет хөрөнгө	1,499,840,794.09	1,483,332,650.74
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,351,384,839.76	1,351,384,839.76
39202	Хуримтлагдсан элэгдэл	-39,763,310.89	-68,918,232.25
39203	Авто-тээврийн хэрэгсэл	21,400,000.00	21,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-21,400,000.00	-21,400,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	41,398,604.00	47,596,004.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-20,774,375.18	-26,162,647.95
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	73,453,607.00	78,990,477.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-26,108,481.60	-32,854,496.32
39217	Ном	120,249,911.00	133,296,706.00
39300	Биет бус хөрөнгө	21,026,666.55	20,849,999.92
39301	Программ хангамж	5,829,500.00	5,829,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-5,602,833.45	-5,779,500.08
39303	Бусад биет бус хөрөнгө	20,800,000.00	20,800,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,541,447,280.04	1,529,028,344.06
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,541,447,280.04	1,529,028,344.06
51	Засгийн газрын хувь оролцоо	1,541,447,280.04	1,529,028,344.06
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	131,839,078.00	131,839,078.00
51200	Хуримтлагдсан үр дүн	1,360,154,637.61	1,347,735,701.63
51210	Өмнөх үеийн үр дүн	1,327,421,873.55	1,360,154,637.61
51220	Тайлант үеийн үр дүн	32,732,764.06	-12,418,935.98
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	49,453,564.43	49,453,564.43
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,541,447,280.04	1,529,028,344.06

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	378,132,040.00	327,207,655.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	26,076,740.00	6,221,755.50
120	Нийтлэг татварын бус орлого	26,076,740.00	6,221,755.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	26,076,740.00	6,221,755.50
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	0.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	26,076,740.00	5,921,755.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	352,055,300.00	320,985,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	1,250,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	352,055,300.00	319,735,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	352,055,300.00	319,735,900.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	345,399,275.94	339,626,591.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	345,399,275.94	339,626,591.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	335,391,940.34	330,142,510.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	186,743,110.00	182,199,234.00
210101	Үндсэн цалин	186,743,110.00	182,199,234.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,768,312.00	23,079,932.00
210201	Тэтгэврийн даатгал	15,873,165.00	16,389,875.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,867,430.00	1,822,571.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,493,945.00	1,458,057.00
210204	Ажилгүйдлийн даатгал	310,338.00	298,948.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,223,434.00	3,110,481.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,916,954.00	58,818,928.00
210301	Гэрэл, цахилгаан	2,596,088.00	2,552,344.00
210302	Түлш, халаалт	60,733,990.00	55,438,020.00
210303	Цэвэр, бохир ус	2,586,876.00	828,564.00
210304	Байрны түрээс	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,089,434.00	14,070,861.00
210401	Бичиг хэрэг	3,561,900.00	4,643,700.00
210402	Тээвэр, шатахуун	1,563,194.00	2,121,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	880,215.00	596,961.00
210404	Ном, хэвлэл	2,205,525.00	534,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	97,000.00	65,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,781,600.00	6,109,450.00
2105	Нормативт зардал	433,000.00	180,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	433,000.00	180,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,894,500.00	6,114,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	429,000.00

210604	Урсгал засвар	3,894,500.00	5,685,500.00
2107	Томилолт, зочны зардал	2,544,000.00	2,676,400.00
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	2,544,000.00	2,676,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	633,260.00	702,780.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	633,260.00	702,780.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,369,370.34	42,299,875.48
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	834,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	38,369,370.34	41,465,875.48
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,007,335.60	9,484,081.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,899,350.00	6,924,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,899,350.00	6,924,900.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	60,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	60,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,107,985.60	2,499,181.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,107,985.60	2,499,181.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	32,732,764.06	-12,418,935.98
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	32,732,764.06	-12,418,935.98

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	352,055,300.00	321,285,900.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	352,055,300.00	321,285,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	1,550,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	1,250,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	300,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	352,055,300.00	319,735,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	352,055,300.00	319,735,900.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	318,604,400.00	302,426,590.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	318,604,400.00	302,426,590.00

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	308,597,064.40	292,942,509.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	187,095,043.40	183,426,957.00
210101	Үндсэн цалин	187,095,043.40	183,426,957.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,976,448.00	23,079,933.00
210201	Тэтгэврийн даатгал	16,019,449.00	16,389,875.65
210202	Тэтгэмжийн даатгал	1,884,641.00	1,822,570.63
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,507,713.00	1,458,056.90
210204	Ажилгүйдлийн даатгал	313,146.00	298,948.44
210205	Эрүүл мэндийн даатгал	3,251,499.00	3,110,481.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,916,954.00	58,818,928.00
210301	Гэрэл, цахилгаан	2,596,088.00	2,552,344.00
210302	Түлш, халаалт	60,733,990.00	55,438,020.00
210303	Цэвэр, бохир ус	2,586,876.00	828,564.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,327,359.00	15,743,011.00
210401	Бичиг хэрэг	3,815,900.00	4,221,400.00
210402	Тээвэр, шатахуун	1,694,444.00	1,994,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	880,215.00	673,961.00
210404	Ном, хэвлэл	2,978,900.00	1,016,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	97,000.00	65,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,860,900.00	7,771,150.00
2105	Нормативт зардал	780,000.00	180,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	780,000.00	180,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,324,000.00	7,314,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	300,000.00	429,000.00
210604	Урсгал засвар	4,024,000.00	6,885,500.00
2107	Томилолт, зочны зардал	2,544,000.00	2,676,400.00
210702	Дотоод албан томилолт	2,544,000.00	2,676,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	633,260.00	702,780.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	633,260.00	702,780.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	1,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	1,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,007,335.60	9,484,081.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,899,350.00	6,924,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,899,350.00	6,924,900.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,107,985.60	2,499,181.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,107,985.60	2,499,181.00

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	33,450,900.00	18,859,310.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	33,450,900.00	18,859,310.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	33,450,900.00	18,859,310.00
2200	Дотоод эх үүсвэрээр	33,450,900.00	18,859,310.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	33,450,900.00	18,859,310.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-33,450,900.00	-18,859,310.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	131,839,078.00	49,453,564.43	1,327,421,873.55	1,508,714,515.98
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	131,839,078.00	49,453,564.43	1,327,421,873.55	1,508,714,515.98
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	32,732,764.06	32,732,764.06
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	131,839,078.00	49,453,564.43	1,360,154,637.61	1,541,447,280.04
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	131,839,078.00	49,453,564.43	1,360,154,637.61	1,541,447,280.04
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	131,839,078.00	49,453,564.43	1,360,154,637.61	1,541,447,280.04
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-12,418,935.98	-12,418,935.98
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	131,839,078.00	49,453,564.43	1,347,735,701.63	1,529,028,344.06

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	319,735,900.00	317,236,719.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	319,735,900.00	317,236,719.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	312,811,000.00	310,311,819.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	183,610,300.00	183,426,957.00
210101	Үндсэн цалин	183,610,300.00	183,426,957.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,781,300.00	23,079,933.00
210201	Тэтгэврийн даатгал	16,781,300.00	16,389,875.65
210202	Тэтгэмжийн даатгал	1,750,000.00	1,822,570.63

210203	ҮОМШӨ-ний даатгал	1,400,000.00	1,458,056.90
210204	Ажилгүйдлийн даатгал	350,000.00	298,948.44
210205	Эрүүл мэндийн даатгал	3,500,000.00	3,110,481.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,283,200.00	58,818,928.00
210301	Гэрэл, цахилгаан	2,750,000.00	2,552,344.00
210302	Түлш, халаалт	55,439,200.00	55,438,020.00
210303	Цэвэр, бохир ус	1,094,000.00	828,564.00
210304	Байрны түрээс	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,041,900.00	27,814,921.00
210401	Бичиг хэрэг	4,150,000.00	4,121,400.00
210402	Тээвэр, шатахуун	1,995,100.00	1,994,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,006,800.00	673,961.00
210404	Ном, хэвлэл	13,480,000.00	13,678,610.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	110,000.00	65,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,300,000.00	7,281,150.00
2105	Нормативт зардал	180,000.00	180,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	0.00
210502	Хоол, хүнс	0.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	180,000.00	180,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,070,000.00	12,611,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,200,000.00	6,197,400.00
210602	Тавилга	0.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	0.00
210604	Урсгал засвар	6,870,000.00	6,414,500.00
2107	Томилолт, зочны зардал	3,000,000.00	2,676,400.00
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	3,000,000.00	2,676,400.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	844,300.00	702,780.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	844,300.00	702,780.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	1,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	1,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,924,900.00	6,924,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,924,900.00	6,924,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,924,900.00	6,924,900.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	319,735,900.00	319,735,900.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	319,735,900.00	319,735,900.00
320001	Орон нутгийн төсвөөс	319,735,900.00	319,735,900.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	1,550,000.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	1,550,000.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	1,490,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	-	590,000.0
210401	Бичиг хэрэг		100,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		490,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	900,000.0
210601	Багаж, техник, хэрэгсэл		429,000.0
210604	Урсгал засвар		471,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	60,000.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	60,000.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		60,000.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	1,550,000.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,550,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,250,000.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	300,000.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Нийтийн номын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Э.Сүнжидмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Нийтийн номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 6 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Нийтийн номын сан нь хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх үйл ажиллагааныхаа хүрээнд нийтэд номын сангийн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Харин Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийтийн номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 317.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 6.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 5.1 сая төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 327.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 6.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 5.2 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Нийтийн номын сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1.1 хувиар буюу 16.8 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Мөнгөн хөрөнгийн эхний болон эцсийн үлдэгдэлгүй байна.

Авлага дансны эхний үлдэгдэл 1.6 сая төгрөг, тайланд онд 1.2 сая төгрөгөөр нэмэгдэж эцсийн үлдэгдэл 2.8 сая төгрөг болж өссөн нь шүүхийн шийдвэрээр ажилтанд олгох цалингийн нөхөн олговор олгосонтой холбоотойгоор авлага нэмэгдсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 28.9 сая төгрөг болж 8.4 сая төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал, сэлбэг хэрэгсэл зардал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 21.2 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, үйл ажиллагаандаа 14.1 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 26.1 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 24.7 сая төгрөг болж өссөн үнэ төлбөргүй 5.9 сая төгрөгийн хөрөнгө, 18.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдаж авсантай холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,533.2 сая төгрөг болж 8.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 1,533.2 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 339.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 19.8 сая төгрөгөөр бууруулж, 319.7 сая төгрөгөөр баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 2 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 319.7 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 319.7 сая төгрөгийн санхүүжилт авч, нэмэлт санхүүжилтийн дансанд 1.5 сая төгрөг, нийт 321.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 318.7 сая төгрөгийг зарцуулж 2.6 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 317.2 сая төгрөг буюу 99.0 хувьтай зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Нэмэлт санхүүжилтийн дансаар 1.5 сая төгрөгийн орлого хүлээн авсан байна. Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн

захирагчид хуваарилсан хөрөнгө 1.3 сая төгрөгийг, үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих 0.3 сая төгрөгийг тайлагнажээ.

Нэмэлт санхүүжилтийн орлогоос бичиг хэрэг, аж ахуйн материал, камер холбох зардалд тус тус зарцуулжээ.

Нэмэлт санхүүжилтийн орлого, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд аудит хамрагдсан 28 мэдээллийн 333.7 сая төгрөгийн мэдээллээс, 25 мэдээллийн 317.0 сая төгрөгийн мэдээллийг бүрэн оруулж, 3 мэдээллийн 16.7 сая төгрөгийн мэдээллийг дутуу оруулсан байна. Горим сорил хэрэгжүүлсний үр дүнд шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Төсвийн хэмнэлтийн талаар:

Батлагдсан төсвийн зардлын 10 хувийн төсвийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 16.6 сая төгрөгийн төлбөрийн акт, 11.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 8.7 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Дээд шатны төсөв захирагчийн зөвшөөрөлгүйгээр нэмэлт орлого олж үйл ажиллагаанд зарцуулсан,
2. Улирлын ажлын төлөвлөгөөг үндэслэн ур чадварын нэмэгдлийг хавтгайруулан олгодог зөрчлийг арилгасан ,
3. Ажлын үр дүн буурсан ажилтанд ур чадварын нэмэгдэл олгосон,
4. Аймгийн ИТХ-ын 2009 оны 51 дүгээр тогтоолыг мөрдөж ажилласан
5. Төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх нь зүйтэй гэж үзлээ.

6. Батлагдсан төсвийн зардлын 10 хувийн төсвийн хэмнэлт гаргаж ажиллаагүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 31.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 17.3 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 0.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 13.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын 16.5 сая төгрөгийн алдааг залрууллаа.

4.2 Төлбөрийн акт

Номын сангийн хуучин барилгыг түрээслүүлсэн боловч орлогыг 0.3 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх," Номын сангийн дарга, Алтайн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих Хишиг холбоо НҮТББ-тай байгуулсан үл хөдлөх хөрөнгө ашиглалтын гэрээ гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн ба зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Тус байгууллагын дарга нь Боловсрол соёл урлагийн газрын даргын тушаалаар ур чадварын нэмэгдэл 0.4 сая төгрөгийг илүү тооцон олгосон нь Монгол Улсын засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт 2-т "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг тухайн байгууллагын төсвийн шууд захирагч шийдвэрлэнэ" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн ба зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

Хөрөнгийн тооллогоор тус байгууллагад бүртгэлтэй 4 ширээ, 3 сандал, 2 суурин компьютер нийт 3.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө биетээр байхгүй Соёлын газарт ашиглагдаж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т "Өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах" гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Цалингийн нөхөн олговортой төсөв хохирсон 2.2 сая төгрөг, ХХОАТ-ын авлага 0.1 сая төгрөг, НДШ-ийн авлага 0.4 сая тус тус тус авлагатай нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Санхүүгийн тайлан, Татварын тодорхойлолт 2.7 сая төгрөгөөр зөрүүтэй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" гэсэн заалттай нийцэхгүй, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Тус байгууллага нь Алтайн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих Хишиг холбоо НҮТББ-тай номын сангийн хуучин барилга болох 280м2 талбайг нэг жилийн 0.6 сая төгрөгөөр түрээслэх гэрээ байгуулсан байна. Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн баталсан тогтоолоор тооцож үзэхэд 4.7 сая төгрөгийн түрээсийн орлого төвлөрүүлэхээр байгаа нь Номын сангийн дарга, Алтайн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих Хишиг холбоо НҮТББ-тай байгуулсан үл хөдлөх хөрөнгө ашиглалтын гэрээ, Аймгийн ИТХ-ын 2009 оны 51 дүгээр тогтоол дугаар тогтоол/ гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн ба зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Шилэн дансны цахим хуудсанд аудит хамрагдсан 28 мэдээллийн 333.7 сая төгрөгийн мэдээллээс, 25 мэдээллийн 317.0 сая төгрөгийн мэдээллийг бүрэн оруулж, 3 мэдээллийн 16.7 сая төгрөгийн мэдээллийг дутуу оруулсан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоол "Журам шинэчлэн батлах тухай" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн ба зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Төсвийн хэмнэлтийн гормын зөрчиж 10 хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй нь: /Засгийн газрын 2021 оны 2 сарын 7-ны өдрийн 1.1-т/ үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас, доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах/ гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн ба зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Нийтийн номын сан	11	31.7	3	17.3	2	0.6	6	13.7		
5	Дүн	11	31.7	3	17.3	2	0.6	6	13.7		